



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 01

Чойр

Ажил хүлээлцүүлэх комисс томилох тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4.1.1, 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар шилжүүлэн томилох тухай” 407 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Соёл-Эрдэнийн Уранцэцэгийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн даргын албан тушаалд томилсонтой холбогдуулан ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

А.Отгонтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд:

Б.Ганбаяр (Мэргэжлийн хяналтын газрын дарга, салбар зөвлөлийн гишүүн)

Ж.Оюунбилэг (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, салбар зөвлөлийн гишүүн)

2. Нарийн бичгийн даргын ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хүлээлцүүлж, төрийн албаны зөвлөлд ажил хүлээлцүүлсэн тухай шийдвэр, тэмдэглэлийг хүргүүлэхийг комиссын дарга (А.Отгонтуяа), нарийн бичгийн даргын ажлыг хүлээлгэн өгөхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (М.Анхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 03

Чойр

Төрийн захиргааны туслах түшмэлийн гүйцэтгэх  
албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт  
зохион байгуулах комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2.2, 33.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.2, 3.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.3, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны туслах түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Б.Ганбаяр (Мэргэжлийн хяналтын газрын дарга) Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Нарийн бичгийн дарга:

М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд:

Б.Сарантуяа (Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Ж.Оюунбилэг (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Б.Нэргүйцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

4894100029

2. Төрийн албаны тусгай шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тайлан, мэдээг нэгтгэн танилцуулахыг тусгай шалгалт зохион байгуулах комисс (Б.Ганбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



~~Д.СОДНОМ~~



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 04

Чойр

Комисс томилох тухай

Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн 59 дүгээр тогтоол "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3.6.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянтал сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ширэндэвийн Шинэбаярын шаардлага хүргүүлэх тухай албан бичгийн дагуу нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

С.Уранцэцэг (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Нарийн бичгийн дарга:

М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд:

Б.Нэргүйцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Б.Ганбаяр (Мэргэжлийн хяналтын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

А.Отгонтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

2. Хууль тогтоомжийн хүрээнд хяналт, шалгалтыг зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг комиссын дарга (С.Уранцэцэг) -т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ

4292100031



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 05

Чойр

Төрийн жинхэнэ албаны дэс  
түшмэлийн гүйцэтгэх албан  
тушаалд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч 70.8 оноогоор тэнцсэн Дансрангийн Эрдэнэжаргалыг Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн Тамгын газрын Мэдээлэл, лавлагааны мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дарга (Д.Сувдаа)-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 06

Чойр

Төрийн жинхэнэ албаны дэс  
түшмэлийн гүйцэтгэх албан  
тушаалд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч хамгийн өндөр 40.0 оноогоор тэнцсэн Өлзийсайханы Бямбасайханыг Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн Тамгын газрын Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дарга (Д.Сувдаа)-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

429190021



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 02

Чойр

Төрийн жинхэнэ албаны дэс  
түшмэлийн гүйцэтгэх албан  
тушаалд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч хамгийн өндөр 61.8 оноогоор тэнцсэн Отгонгомбожавын Батхүүг Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны Газар зүйн мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сарантуяа)-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХАЭГ 115  
05

429190016



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 08

Чойр

Төрийн жинхэнэ албаны дэс  
түшмэлийн гүйцэтгэх албан  
тушаалд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч хамгийн өндөр 51 оноогоор тэнцсэн Батнасангийн Пүрэвсүрэнг Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргааны Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сарантуяа)-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ







ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 09

Чойр

Төрийн жинхэнэ албаны дэс  
түшмэлийн гүйцэтгэх албан  
тушаалд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч хамгийн өндөр 72.2 оноогоор тэнцсэн Энхзаяагийн Гантуяаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Х.Буянбаяр)-т санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХЛ9115

429190019



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 10

Чойр

Төрийн жинхэнэ албаны туслах  
түшмэлийн албан тушаалд  
томилуулахаар нэр дэвшүүлэх  
тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны туслах түшмэлийн албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч хамгийн өндөр 58 оноогоор тэнцсэн Сэрээдоржийн Оюунтүлхүүрийг Баянтал сумын Засаг даргын Тамгын газарт Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

429190022



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 11

Чойр

Төрийн захиргааны албан хаагчид  
зэрэг дэв шинээр болон ахиулан  
олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зэрэг дэв шинээр болон ахиулан олгох төрийн захиргааны албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох саналыг Аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Уранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХА0115  
06

429190014



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 12

Чойр

**Төрийн албаны ерөнхий шалгалт  
зохион байгуулах салбар комисс  
томилох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын 3.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.3, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр зохион байгуулагдах төрийн албаны ерөнхий шалгалт авах ажлыг зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

Нарийн бичгийн дарга:

С.Уранцэцэг (Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Гишүүд:

Б.Ганбаяр (Мэргэжлийн хяналтын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

Ж.Оюунбилэг (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

Б.Сарантуяа (Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

Д.Сувдаа (Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

А.Отгонтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

Ц.Баярхүү (Аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

Б.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологийн ажилтан)

Д.Оюунсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Жанчив (Онцгой байдлын газрын Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)

Ө.Шинэ-Од (Говьсүмбэр аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн Мэдээлэл технологийн ажилтан)

Г.Лувсанчоглон (Говьсүмбэр аймаг дахь Тагнуулын хэлтсийн ажилтан)

2.Төрийн албаны ерөнхий шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тайлан мэдээг нэгтгэн танилцуулахыг салбар комисс /М.Анхбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 03

Чойр

Урамшуулал олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 7.1, 7.3.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журмын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулахад шалгалт авах танхимын техник хэрэгслийн бэлэн байдал, сүлжээ, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын бэлтгэлийг хангах мэдээллийн технологийн ажилтнаар ажилласан аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан Б.Түвшинжаргал, Онцгой байдлын газрын ажилтан Д.Жанчив нарт урамшуулал олгосугай.

2.Урамшуулалд шаардагдах 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийг Төрийн албаны зөвлөлөөс шилжиж ирсэн төрийн албаны ерөнхий шалгалтын хураамжийн зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Гүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОДНОМ



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 14

Чойр

Төрийн захиргааны дэс түшмэлийн  
гүйцэтгэх албан тушаалын сул орон  
тоог нөхөх тусгай шалгалт зохион  
байгуулах комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2.2, 33.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.2, 3.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.3, 5.7, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

М.Анхбаяр  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд:

Б.Нэргүйцэцэг  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Ж.Оюунбилэг  
(Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)  
Ц.Баярхүү

Нарийн бичгийн дарга:

(Аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга,  
Төрийн албаны зөвлөлийн салбар  
зөвлөлийн гишүүн)

С.Уранцэцэг

(Төрийн албаны зөвлөлийн салбар  
зөвлөлийн нарийн бичгийн дарга,  
Төрийн албаны салбар зөвлөлийн  
гишүүн)

2.Төрийн албаны тусгай шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тайлан, мэдээг нэгтгэн танилцуулахыг тусгай шалгалт зохион байгуулах комисс (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 15

Чойр

**Төрийн үйлчилгээний байгууллагын  
төсвийн шууд захирагчийн сонгон  
шалгаруулалтыг зохион байгуулах  
комисс томилох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 1.4.2, 3.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.3, 5.7, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Сувдаа

(Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд:

Б.Сарантуяа

(Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Д.Батцэцэг

(Ахмадын төлөөлөл, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Б.Нэргүйцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Нарийн бичгийн дарга:

Б.Ганбаяр

(Мэргэжлийн хяналтын газрын дарга,  
Төрийн албаны салбар зөвлөлийн  
гишүүн

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж,  
тайлан мэдээг нэгтгэн танилцуулахыг комисс (Д.Сувдаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 16

Чойр

Төрийн захиргааны туслах түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2.2, 33.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.2, 3.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.3, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны туслах түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Б.Ганбаяр  
(Мэргэжлийн хяналтын газрын дарга)  
Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд:

Б.Сарантуяа  
(Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)  
Ж.Оюунбилэг

(Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Ц.Баярхүү  
(Аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга,  
Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Нарийн бичгийн дарга:

Б.Нэргүйцэцэг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

2.Төрийн албаны тусгай шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тайлан, мэдээг нэгтгэн танилцуулахыг тусгай шалгалт зохион байгуулах комисс (Б.Ганбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 17

Чойр

Төрийн захиргааны дэс түшмэлийн удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2.2, 33.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.2, 3.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.3, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны дэс түшмэлийн удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

М.Анхбаяр

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд:

Ж.Оюунбилэг

(Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Ц.Баярхүү

(Цагдаагийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Б.Нэргүйцэцэг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн

Нарийн бичгийн дарга:

дарга, Төрийн албаны зөвлөлийн  
салбар зөвлөлийн гишүүн)

С.Уранцэцэг

(Төрийн албаны зөвлөлийн салбар  
зөвлөлийн нарийн бичгийн дарга,  
Төрийн албаны салбар зөвлөлийн  
гишүүн)

2.Төрийн албаны тусгай шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион  
байгуулж, тайлан, мэдээг нэгтгэн танилцуулахыг тусгай шалгалт зохион байгуулах  
комисс (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 18


Чойр

Төрийн захиргааны дэс түшмэлийн  
гүйцэтгэх албан тушаалд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч 38 оноогоор тэнцсэн Оюунчимэгийн Отгонбаатарыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, ялган тэмдэглэгээ, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнээр томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Н.Даваахүү)-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 19

Чойр

Төрийн үйлчилгээний төсвийн шууд  
захирагчаар томилуулахаар нэр  
дэвшүүлэх тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 1.4.2, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4, 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад орж 68.7 оноогоор тэнцсэн Батсүх овогтой Энхмэндийг Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Баянтал сумын Засаг дарга (Г.Анхбаяр)-т санал болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 20

Чойр

Төрийн захиргааны дэс түшмэлийн  
гүйцэтгэх албан тушаалд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.3, 7.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1, 3.5.4 5.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч 65.8 оноогоор тэнцсэн Заяандарь овогтой Сумъяажавыг Татварын хэлтсийн сумын татварын улсын байцаагчаар томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшсэн иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтанд заасан шаардлагыг хангуулан томилж ажиллуулахыг Татварын хэлтсийн дарга (П.Энх-Оюун)-д санал болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 21

Чойр

Төрийн албан хаагчийн тангараг  
өргүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийг тангараг өргүүлэх ёслолын журам”, “Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ын 4.3, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн, туршилтаар ажиллах хугацаандаа цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Газрын харилцаа, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн Зоригтын Саранцэцэг, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Гонгорбаатарын Баяр-Ундрал, Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Болдын Болортуяа, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, эдийн засгийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Магвандоржын Долгормаа, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Батсуурийн Уранчимэг, Говьсүмбэр аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах Пүрвээгийн Рэнцэндорж, Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах Даваагийн Урангоо, Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах Батбаярын Чанцалдулам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч Баярсайханы Шархүү, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Баярцэнгэлийн Урангоо, Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Ганзоригын Мөнхдэлгэр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн зах зээлийн болон ажлын байрны шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Мандахын Номинжаргал, Өрхийн хөгжил,

хөтөлбөрүүдийн хэрэгжилт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Доржын Тунгалагсайхан, Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Байгалмаагийн Энхдэлгэр, Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Найдансүрэнгийн Мөнхмандах нарыг төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэхээр аймгийн Засаг дарга (Г.Батзам)-д уламжилсугай.

2.Тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг журмын дагуу зохион байгуулан, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Уранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ